

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/94/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsuren.b@audit.mn">dolgorsuren.b@audit.mn</a></p> <p>Ахлах аудитор Ж.Мөнхтуул Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:munkhtuulj@audit.gov.mn">munkhtuulj@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХС	Батарей хуримтлуурын станц
ДҮТ ТӨХХК	Диспетчерийн Үндэсний Төв Төрийн Өмчит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/311

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус төслийн зээлийн хэлэлцээр нь 2020 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, 2025 оны 3 дугаар сарын 31-нд дуусгавар болохоор батлагдсан байдаг бөгөөд төслийн 80МВт/200МВтц хүчин чадалтай батарей хуримтлуурын станцын эхний 2 жилийн ашиглалт, засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх гэрээт ажил 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох бөгөөд гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төслийн удирдах хорооны 16 дугаар зөвлөмжийн дагуу төслийн хэрэгжих хугацааг сунгуулах хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж, Азийн хөгжлийн банкны 2025 оны 3 дугаар сарын 31-ний 89/25 дугаар албан бичгээр төсөл хэрэгжих хугацааг 9 сараар буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон байна.

Азийн хөгжлийн банкнаас олгох нийт 103,000.0 мянган ам.долларын санхүүжилтээс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 92,467.6 мянган ам.доллар буюу 89.7 хувийн санхүүжилтийг зарцуулсан байна. “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур” төслийн хүрээнд баригдсан 80 МВт/200 МВт.ц чадалтай том чадлын батарей хуримтлуурын станцын ашиглалт болон зээлийн эргэн төлөлтийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК хариуцан ажиллаж байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт Азийн хөгжлийн банкны “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл”-ийн хүрээнд хэрэгжсэн 80 МВт-ын чадалтай 200 МВт.ц-ийн багтаамжтай “Сонгино” батарей хуримтлуурын станц, 35/110 кВ-ын дэд станц, удирдлагын барилга, 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийг Эрчим хүчний яамны 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 16/2025 дугаартай эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтийн дагуу бүрэн ашиглалтад оруулж, ашиглагч болох “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д хүлээлгэн өгсөн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Төслийн нэгж нь 2025 оны үйл ажиллагааны 2 зорилтын хүрээнд нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжиж 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсөв захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. An* Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>290,082,101,776.66</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>240,829,915.47</b>	
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>240,829,915.47</b>	
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>28,442,274.99</b>	
31211	Төрийн сангийн харилцах	28,442,274.99	
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	<b>212,387,640.48</b>	
31221	Төрийн сангийн харилцах	212,387,640.48	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>11,860,534.45</b>	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	111,995.82	
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	341,142.25	
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>11,407,396.38</b>	
33510	Байгууллагаас авах авлага	11,407,396.38	
<b>36</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>289,829,411,326.74</b>	
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	289,829,411,326.74	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,093,673.39</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>44,093,673.39</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>42,443,673.39</b>	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,939,760.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,557,952.69)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,538,533.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,476,666.92)	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,650,000.00</b>	
39301	Програм хангамж	3,960,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,310,000.00)	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>290,126,195,450.05</b>	
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>61,966,851.34</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>61,966,851.34</b>	
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>61,966,851.34</b>	
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,140,325.34	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>58,826,526.00</b>	
41361	Байгууллагад төлөх өглөг	47,447,826.00	
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	11,378,700.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>290,064,228,598.71</b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>290,064,228,598.71</b>	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>290,064,228,598.71</b>	
51210	Өмнөх үеийн үр дүн	144,026,407,836.74	290,064,228,598.71
51220	Тайлант үеийн үр дүн	146,037,820,761.97	(290,064,228,598.71)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>290,126,195,450.05</b>	

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>159,439,286,317.42</b>	<b>36,836,748,278.09</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>159,439,286,317.42</b>	<b>36,836,748,278.09</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>159,439,286,317.42</b>	<b>36,836,748,278.09</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>159,439,286,317.42</b>	<b>36,836,748,278.09</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	159,439,286,317.42	36,836,748,278.09
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>13,400,503,361.42</b>	<b>17,819,805,117.69</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,400,503,361.42</b>	<b>17,819,805,117.69</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,400,503,361.42</b>	<b>17,809,548,777.25</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>326,197,300.00</b>	<b>328,080,000.00</b>
210101	Үндсэн цалин	326,197,300.00	328,080,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>40,498,816.50</b>	<b>41,010,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,498,816.50	41,010,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,180,000.00</b>	<b>61,523,874.00</b>
210304	Байрны түрээс	78,180,000.00	61,523,874.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,014,005.47</b>	<b>4,381,092.31</b>
210401	Бичиг хэрэг	1,880,626.00	2,870,129.00
210402	Тээвэр, шатахуун	2,267,000.00	817,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	866,379.47	693,963.31
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,933,447,768.32</b>	<b>17,358,044,887.49</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,061,630,264.00	1,655,317,949.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,000,000.00	60,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,830,627,690.82	15,642,726,938.27
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,165,471.13</b>	<b>16,508,923.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,880,937.00	1,300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,284,534.13	15,208,923.45
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>10,256,340.44</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>10,256,340.44</b>
21311	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>10,256,340.44</b>
213112	<b>Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал</b>		<b>10,256,340.44</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		10,256,340.44
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>146,038,782,956.01</b>	<b>19,016,943,160.40</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>150,162.45</b>	<b>5,190,264.38</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	150,162.45	5,190,264.38
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,112,356.49</b>	<b>309,081,404,231.63</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		28,884,749.95
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,112,356.49	8,246,553.19
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал		309,044,272,928.50
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(962,194.04)</b>	<b>(309,076,213,967.25)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>146,037,820,761.97</b>	<b>(290,059,270,806.85)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>366,858,151.46</b>	<b>331,475,519.34</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>366,858,151.46</b>	<b>331,475,519.34</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>366,858,151.46</b>	<b>331,475,519.34</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	366,858,151.46	331,475,519.34
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>		<b>10,500,070.94</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>10,500,070.94</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>243,730.50</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>243,730.50</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		243,730.50
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>10,256,340.44</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>10,256,340.44</b>
21311	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>10,256,340.44</b>
213112	<b>Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал</b>		<b>10,256,340.44</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		10,256,340.44
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>366,688,337.96</b>	<b>(10,500,070.94)</b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>150,162.45</b>	<b>336,665,783.72</b>
145004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	150,162.45	5,190,264.38
1451	<b>Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах</b>		<b>331,475,519.34</b>
145101	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах /СЯ-ХЯ/		331,475,519.34
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>480,186,144.43</b>	<b>566,987,029.12</b>
232	<b>Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл</b>	<b>480,186,144.43</b>	<b>566,987,029.12</b>
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	480,186,144.43	566,987,029.12
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>1,112,356.49</b>	<b>8,599.13</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,112,356.49	8,599.13
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(481,148,338.47)</b>	<b>(230,329,844.53)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(114,290,187.01)</b>	<b>(240,829,915.47)</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>355,120,102.48</b>	<b>240,829,915.47</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>240,829,915.47</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		<b>144,026,407,836.74</b>	<b>144,026,407,836.74</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>144,026,407,836.74</b>	<b>144,026,407,836.74</b>
Тайлант үеийн үр дүн		146,037,820,761.97	146,037,820,761.97
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		<b>290,064,228,598.71</b>	<b>290,064,228,598.71</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>290,064,228,598.71</b>	<b>290,064,228,598.71</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		(4,957,791.86)	(4,957,791.86)
Тайлант үеийн үр дүн		(290,059,270,806.85)	(290,059,270,806.85)
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>12</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>22,787,034,900.00</b>	<b>21,201,655,070.32</b>	<b>1,585,379,829.68</b>	<b>93.0</b>
1200044	Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого	22,787,034,900.00	21,201,655,070.32	1,585,379,829.68	93.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>22,787,034,900.00</b>	<b>21,437,303,320.53</b>	<b>1,349,731,579.47</b>	<b>94.1</b>
<b>23</b>	<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр дүн</b>	<b>22,787,034,900.00</b>	<b>21,437,303,320.53</b>	<b>1,349,731,579.47</b>	<b>94.1</b>
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	22,787,034,900.00	21,437,303,320.53	1,349,731,579.47	94.1
	<b>Төсвийн тохируулгын дүн</b>		<b>5,181,665.25</b>		
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		(240,829,915.47)		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(240,829,915.47)		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(240,829,915.47)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		240,829,915.47		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь төвийн бүсийн эрчим хүчний системд 80МВт/200МВт.ц чадалтай том чадлын эрчим хүч хуримтлуулах, зай хураагуурын системийг суурилуулан ашиглалтад оруулж, эрчим хүчний системийн тогтвортой үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаа явуулахад оршино.

Төслийн төсөвт өртгийн 87.0 хувийг Азийн хөгжлийн банкны зээлээр, 2.6 хувийг тус банкны буцалтгүй тусламжаар, Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр 10.4 хувийг тус тус санхүүжүүлэхээр байна.

- Азийн хөгжлийн банк, Ердийн капитал эх үүсвэр (Зээл 3874-MON) 100.0 сая ам.доллар;
- Азийн Хөгжлийн Банк, Японы Технологи хөгжлийн сан (Буцалтгүй тусламж 0696-MON (EF) 3.0 сая ам.доллар;
- Монгол Улсын Засгийн газар 11.95 сая ам.доллар.

Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2030 онд 30.0 хувь хүртэл нэмэгдүүлэх зорилготой байна.

Монгол Улсын Засгийн газар Азийн Хөгжлийн банкт байгуулсан хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээний дагуу 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж төслийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт 100.0 хувийн гүйцэтгэлтэй амжилттай хэрэгжиж дууссан.

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн үйл ажиллагаа 2020 оны 05 дугаар сарын 14-нөөс эхэлсэн бөгөөд 2020-2025 оны хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгсэн байна. Үүнд:

#### Үр дүн 1: Том чадлын хуримтлуурын системийг суурилуулж, хүлээлгэн өгөх, эхний 2 жилийн ашиглалт засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх

- 80 МВт/200МВт.ц хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын байгууламж, 35кВ-ын хаалттай хуваарилах байгууламж, 110кВ-ын хүчдэлийн түвшинтэй 100МВА-ын чадалтай 2 үндсэн трансформаторын угсралт суурилуулалт, 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станцын 110кВ-ын ИХБ-ыг хоёр гаргалгаагаар өргөтгөх, удирдлагын байр, галын усны барилгын барилга угсралтын ажил, холбоо, дохиолол СКАДА мэдээллийн системийг ДҮТ ТӨХХК-тай холбох, хуримтлуурын байгууламжийг алсаас удирдах EMS системээр тоноглогдсон тусгай зориулалтын компьютерыг ЦДҮС ТӨХК болон ДҮТ ТӨХХК-ийн төв диспетчерийн өрөөнд тус тус суурилуулах ажлуудыг бүрэн хийсэн.
- Техникийн комиссын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн ЭХҮТ-А/180/18/2024 тоот дүгнэлтээр “Сонгино” дэд станцын 110кВ-ын ИХБ-ын хоёр гаргалгаагаар өргөтгөлийг ажиллагаанд залгах шийдвэр гаргаж, Улсын комиссын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 16/2025 тоот дүгнэлтээр төслийн хүрээнд байгуулагдсан байгууламжийг байнгын ажиллагаанд залган өмчлөлийг ашиглагч байгууллага болох ЦДҮС ТӨХК-ийн мэдэлд ашиглалтанд оруулах шийдвэр гаргасан.

#### Үр дүн 2: Институцийн болон байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх.

- 2а. Батарей хуримтлуурын байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний заавар боловсруулж батлуулсан;
- 2б. Ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургалтуудыг зохион байгуулж, ЦДҮС ТӨХК болон ДҮТ ТӨХХК-ийн 92 ажилтныг сургаж, дадлагажуулсан;
- 2в. “БХС-ын ашиглалт, засвар үйлчилгээний стратеги дүрэм” баримт бичиг боловсруулж батлуулсан;
- 2г. БХС-ын “Туслах үйлчилгээний зах зээлийн дүрэм, тарифын аргачлал”-ын баримт бичгийг боловсруулж батлуулсан;

- 2д. Эрчим хүчний салбарын 120 эмэгтэй ажилтныг нарийн мэргэжлийн сургалтанд хамруулж, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлсэн;
- 2е. “Эрчим хүчний салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах /2023-2032/ стратеги төлөвлөгөө” баримт бичгийг боловсруулж батлуулсан.

### 3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл нь Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний төслийн нэгж бөгөөд Сангийн сайдын баталсан тушаал шийдвэрүүдийг дагаж мөрдөхөөс гадна Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоол - “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Төсвийн тухай хууль 8, 12, 14, 16, 28, 57, 68 дугаар зүйлүүдэд 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэгт “Гадаадын зээл, тусламжийн бүртгэл”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Эрчим хүчний яамны Дотоод журмыг дагаж мөрддөг.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 290,126.2 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	240,829.9	0.0	(240,829.9)
Авлага	11,860.5	0.0	(11,860.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	289,829,411.3	0.0	(289,829,411.3)
Үндсэн хөрөнгө	44,093.7	0.0	(44,093.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>290,126,195.4</b>	<b>0.0</b>	<b>(290,126,195.4)</b>
Богино хугацаат өр төлбөр	61,966.8	0.0	(61,966.8)
Хуримтлагдсан үр дүн	290,064,228.6	0.0	(290,064,228.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>290,126,195.4</b>	<b>0.0</b>	<b>(290,126,195.4)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр болон хуримтлагдсан үр дүнгийн дансдуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, 240,829.9 мянган төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкнаас 92,501.33 ам.долларын нөхөн дүүргэлт, авлагын эргэн төлөлт болон валютын ханшийн зөрүүгээр нэмэгдэж, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн шилжүүлэг болон тайлант оны үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, 11,860.5 мянган төгрөгөөр буурсан нь түрээсийн барьцаа төлбөрийг түрээсийн зардалд оруулж тооцсонтой холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгө 0.0 мянган төгрөг болж, 289,829,411.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны 5,362,441.52 ам.доллар буюу 19,214,861.6 мянган төгрөгийн барилгын ажлын гүйцэтгэлийн төлбөрүүд гарч, Улсын комиссын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 16/2025 тоот дүгнэлтээр төслийн хүрээнд байгуулагдсан байгууламжийг байнгын ажиллагаанд залган өмчлөлийг ашиглагч байгууллага болох ЦДҮС ТӨХК-ийн мэдэлд шилжүүлэн өгсөнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, 44,093.7 мянган төгрөгөөр буурсан нь 97,438.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 68,553.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг төслийн гүйцэтгэгч байгууллага болох ЦДҮС ТӨХК-д хүлээлгэн өгсөнтэй холбоотой;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж, 61,966.8 мянган төгрөгөөр буурсан нь төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанид санхүүжилтийг олгосонтой холбоотой;
- Хуримтлагдсан үр дүн 290,126,195.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар гадаад зээлийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 122,604,234.9 мянган төгрөгөөр буюу 76.9 хувиар буурсан нь 80МВт/200 МВт цаг хуримтлуурын байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой гэрээт ажлын үлдэгдэл үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна. Тайлант онд буцалтгүй тусламжийн санхүүжилт гараагүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжаас 77,358,186.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлын төсвийг 51,926,900.9 мянган төгрөгөөр бууруулж, 22,787,034.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгийн зардлын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй буюу 2025 оны барилгын ажлын санхүүжилтийн хуваарьтай холбоотой хөрөнгийн зардлын хэмжээг бууруулан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Азийн хөгжлийн банкнаас 21,201,655.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,437,303.3 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь барилгын ажлын төлбөрийг гүйцэтгэлээр зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	22,787,034.9	21,437,303.3	1,349,731.6	94.1
1.1	80104/70207 Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	22,787,034.9	21,437,303.3	1,349,731.6	94.1

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Уг төсөл хэрэгжүүлэгч нэгжийг Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц орон тоог батлах тухай” 174 дүгээр тушаалын дагуу Эрчим хүчний яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлж, ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон.
2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнуудад унаа, хоолны хөнгөлөлт олгоогүй, зөвхөн үндсэн цалингийн зардал гарсан байна.
3. Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээтэй холбоотой зардал гараагүй байна.
4. Тайлант онд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг зохион байгуулаагүй, үүнтэй холбоотой зардал гаргаагүй байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, холбогдох задал гараагүй байна.
6. Тайлант хугацаанд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төслийн хэрэгжилтийн нийт түвшин 100.0 хувь, 2025 оны төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган ам.доллар/

№	Хөтөлбөр	Хэрэг-жих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэг-жилт хувь	Зарцуу-лах төсөв	Зар-цуулсан
1	Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл	2019-2025	Үр дүн 1: 2023 он гэхэд: 80МВт/200МВт.ц багтаамжтай эрчим хүч хуримтлуулах системийг суурилуулах (суурилуулсны дараа ашиглалт үйлчилгээний 2 жил )	100.0%	81,404.3	81,404.3
			Үр дүн 2: 2025 он гэхэд Институтийн болон бүтэц зохион байгуулалтын чадавхыг нэмэгдүүлэх нь (Төслийн менежментийн зөвлөх)	100.0%	1,846.3	1,668.6
<b>Дүн</b>				<b>100.0%</b>	<b>83,250.6</b>	<b>83,072.9</b>

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн санхүүгийн тайлагналтай холбоотой залруулгыг тусгасан болно.

Аудитыг Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Г.Төрсайхан, туслах аудитор Б.Баттогтох нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Мөнхтуул, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 2026/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 13,401,615.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 201,024.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан хэрэгцээнд албан тушаалын суудлын автомашин ашиглаагүй, тавилга эд хогшил худалдан аваагүй, бүтэц орон тоонд өөрчлөлт оруулалгүй баталсан орон тооны хүрээнд ажиллаж, төсвийг зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын гүйлгээнээс 331,379.6 мянган төгрөгийн 3 гүйлгээг, зарлагын гүйлгээнээс 145,137.1 мянган төгрөгийн 10 гүйлгээг бүрэн оруулж, үүнээс 57,841.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан бөгөөд орхигдуулсан мэдээлэл байхгүй байна.

Төслийн нэгжийн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой байдлыг үнэлэхэд мэдээлсэн байдлын хэрэгжилт 98.1 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 90.4 хувь байгаа тул зөрчилгүй хэмээн шийдвэрлэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанаас хоцроон ирүүлсэнтэй холбоотой хариуцлага тооцох албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцох албан шаардлага	1	0.0	1	0.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,915.3 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүү байдлын тайлангаарх 8,098.1 төгрөгийн авлага, 3,140.3 мянган төгрөгийн ажилчдад өгөх өглөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

тайлангийн толилуулга 27 дугаар параграф "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д шударгаар илэрхийлэхийг шаарддаг", санхүүгийн тайлангийн үнэн зөв болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй;

- Орлого үр дүнгийн тайланд 19,980.0 мянган төгрөгийн түрээсийн зардлыг бусад зардлаар тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27 дугаар параграф "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д шударгаар илэрхийлэхийг шаарддаг", санхүүгийн тайлангийн ангилал болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй;
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг буруу ханшаар тооцон 1,696.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлангаарх 8,098.1 төгрөгийн авлага, 3,140.3 мянган төгрөгийн ажилчдад өгөх өглөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан	1	11,238.4			1	11,238.4	1	11,238.4				
Орлого үр дүнгийн тайланд 19,980.0 мянган төгрөгийн түрээсийн зардлыг бусад зардлаар тайлагнасан	1	19,980.0			1	19,980.0	1	19,980.0				
Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг буруу ханшаар тооцон 1,696.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	1,696.9			1	1,696.9	1	1,696.9				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>32,915.3</b>			<b>3</b>	<b>32,915.3</b>	<b>3</b>	<b>32,915.3</b>				

/мянган төгрөгөөр/